

**ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОХ
“СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ”**

1. Түрээслэгчийг сонгон шалгаруулах зарын маягт

Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга:

- СЭМҮТ-ийн “ Г ” байрны 2 давхарт 252 м2 талбайд хоол үйлдвэрлэл явуулж, үйлчлүүлэгч болон ажилчдад халуун хоол, цайгаар үйлчлэх зорилгоор дээрх талбайг түрээслүүлнэ.

Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2026 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 11 цагт
Материал хүлээн авах хаяг	СЭМҮТ-ийн А байрны 2 давхар, 201 тоот өрөө, бичиг хэргийн ажилтан
Материал нээх хугацаа, хаяг байршил	2026 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 12 цагт СЭМҮТ-ийн А байрны 2 давхар, 208 тоот өрөө
Эд хөрөнгө түрээслэх үнийн доод хэмжээ	3,780,000 төгрөг
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Тухайн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай холбогдох зөвшөөрөл
	1. Оролцогч нь сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд, бүрэн бүрдүүлж битүүмжлэн ирүүлнэ. Бүрдүүлсэн материалын жагсаалтыг дугтуйны гадна талд бичсэн байна. 2. Оролцогч нь зард заасан хугацаанд материалаа өөрийн биеэр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр

Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл	дамжуулан түрээслүүлэгчийн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгнө. 3. Оролцогч нь сонгон шалгаруулалтыг нээхээс өмнө татгалзах саналаа ирүүлж болно. 4. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг сонгон шалгаруулалт зохион байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор тухайн байгууллагад гаргана. 5. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна. 6. Сонгон шалгаруулалтын материалын бүрдэл дутуу тохиолдолд оролцогчийг үл маргах журмаар хасна.
Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал	- Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар - Иргэн бол цахим үнэмлэхний хуулбар - Ажлын туршлагын талаарх мэдээлэл / өмнө хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний хуулбар/ - Санхүүгийн чадавхийг нотлох баримт шаардана. Үүнд: Иргэн бол харилцагч банкны тодорхойлолт / зээл/, сүүлийн 1 жилийн дансны хуулга Хуулийн этгээд бол сүүлийн 1 жилийн буюу 2025 оны аудитлагдсан тайлан, татвар, нийгмийн даатгалын тодорхойлолт Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэх, нийгмийн даатгалын төлөлтийн сүүлийн 3 сарын НД 7 маягт ирүүлэх / хуулийн этгээд бол / - Түрээслэх талбайн үнийн санал: Сар бүр 3,780,000 төгрөг

	• Манай байгууллагын эмчлүүлэгчдийн онцлогоос хамаарч үйлчилгээний цэг ажиллуулахад дараах шаардлагуудыг хангасан байна. 1. Хүнсний бүтээгдэхүүн, ус, ундаа, болон түргэн хоол, амттан зэргийг байршуулах зориулалтын хөргүүртэй байх 2. Халуун уух зүйлээр үйлчлэх зориулалтын тоног төхөөрөмжтэй байх 3. Үйлчилгээний цэг ажиллуулах хэсэгт байрлуулах лангуу нь шилэн бус хатуу бат бөх байх 4. Хоол үйдвэрлэлийн тоног төхөөрөмжтэй байх
--	--

Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах:

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Г” байран дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг 99738817 утсаар болон ncmh.gov.mn цахим хуудаснаас авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 34-р хороо, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, А байр, 208 тоот өрөө

Холбогдох албан тушаалтан: Нягтлан бодогч Э.Гэрэлмаа

Утасны дугаар: 99738817